

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг  
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван  
долдугаар хуралдааны тэмдэглэл /2018-12-19/**

Үндэсний зөвлөлийн арван долдугаар хуралдаан 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 15 цагт Уул уурхайн яамны Хурлын танхимд эхлэв.

Хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Үндэсний зөвлөлийн даргыг орлож болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ажлын хэсгийн ахлагчийг төлөөлж мөн яамны уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал, Түлшний бодлогын газрын хэлтсийн дарга Б.Анхбаяр, Сангийн сайдыг төлөөлж Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Байгаль, орчин аялал жуулчлалын сайдыг төлөөлж Хүрээлэн буй орчин, нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Саран, Авлигатай тэмцэх газрын даргыг орлож Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Т.Баярхүү, Үндэсний статистикийн хорооны дарга Ариунзаяаг орлож макро эдийн засгийн хэлтсийн мэргэжилтэн н.Энх-Амгалан, Эрдэнэт үйлдвэр ХХК-ны эдийн засаг, маркетингийн хэлтсийн орлогч дарга Д.Галбаатар, Монголын УУА-ийн ерөнхийлөгч Д.Гантөмөр, Монголросцветмет ХХК-ийн тэргүүлэх мэргэжилтэн М.Болдбаатар, Монполимет ХХК Группын гүйцэтгэх захирал С.Энхтуяаг төлөөлж Санхүүгийн албаны дарга Батбаяр, Энержи ресурс ХХК-ийн гүйцэтгэх захиралыг болон Нүүрс ассоциацийг орлож Энержи ресурс ХХК-ийн Нийгмийн хариуцлага, олон нийтийн харилцааны газрын дарга Б.Сугармаа, Оюутолгой ХХК-ны ерөнхийлөгчийг төлөөлж Гадаад харилцаа, олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн ерөнхий менежер Ж.Сүнжидмаа, Хамтын ажиллагааны ахлах менежер Т.Мөнхбат, Петрочайна дачин тамсаг ХХК-ны ерөнхий нягтлан бодогч н.Болормаа, Нээлттэй нийгэм форумын захирал П.Эрдэнэжаргалыг орлож, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Хариуцлагатай уул уурхай ТББ-ийн ТУЗ-ын гишүүн Д.Сүхбаатар, Монголын байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Н.Наранцэцэг, Ил тод сангийн тэргүүн Д.Цороонжав, Милий монголын газар шороо ТББ-ын тэргүүн Б.Болдбаатар, гүйцэтгэх захирал О.Отгонсайхан, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 21 гишүүд оролцож ирц 70 хувьтай байв. ЗГХЭГ-ын ахлах референт Д.Болд, Татварын ерөнхий газрын даргын орлож байцаагч Г.Батцэнгэл, нар урилгаар оролцов.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпорацийн захирал Ц.Осоргарав, зөвлөх Дэвид Куин, ахлах аудитор Н.Эрдэнэцог, аудитор Эрдэнэбат, Баяржаргал, Энхсайхан, Отгоннаран, Идшинренжин нар болон ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат, хуулийн ажилтан Б.Бадмаараг нар оролцов

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван долдугаар хуралдааныг, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Н.Нандинжаргал нээж, удирдан эхлүүлэв.

Н.Нандинжаргал: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн хуралдааныг Уул уурхайн сайд удирдан явуулах байсан боловч намын хурал давхацсан тул оролцох боломжгүй болсонд Та бүхнээс хүлцэл өчье. Бид Засгийн газрын 289 дүгээр тогтоол гарсныг мэдэж байгаа. Уг тогтоолын дагуу ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн даргаар Уул уурхайн сайд, нарийн бичгийн даргаар Төрийн нарийн бичгийн дарга ажиллахаар болсон. Манай яаманд ирснээр бид хамтран ажиллахад илүү боломжтой байна гэж харж байгаа. Та бүхнээс өнөөдрийн хурлын дэгээ танилцуулаад, шууд хэлэлцэх асуудалдаа орох уу гэдэг дээр санал хураая.

Бүх гишүүд саналыг дэмжсэнээр танилцуулгыг сонсов.



## 1. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны буюу 12 дугаар тайланг хэлэлцэж, батлах тухай

Дэвид Куин: Сайн байцгаана уу, Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би өмнө нь олон удаа Монголд ирж байсан гэхдээ ийм хүйтэн үед ирж байгаагүй юм байна. Би тайлангийн цар хүрээ, нэгтгэлийн ажлын тойм болон тайлангийн явцад илрүүлсэн талаар танилцуулна.

Тайлангийн хамрах хүрээ 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс 2018 оны 12 дугаар сарын 31-ны хооронд байна. Нэгтгэл тайланд нийт 230 компанийг сонгосон. Үүнээс 219 хувийн хэвшлийн уул уурхайн компани, 11 нь ТӨААН, 10 нь орон нутгийн өмчит компани байна. Бид ОУИТБС-ын олон улсын стандартын дагуу тайлангаа бэлтгэдэг. Нэгтгэл тайланг хийхдээ материаллаг зөрүүг тааруулахаас гадна орлогын мэдээлэл, шинээр олгосон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Бенефициарын мэдээлэл, хандив тусламжийн мэдээлэл, ашигласан усны мэдээлэл болон хог хаягдлын мэдээллүүдийг судлан нэгтгэсэн. ОУИТБС-ын тайланд цахим тайлангийн мэдээлэлд байгаа төлбөр орлогын төрөл, орлогыг хүлээн авч буй байгууллагуудын мэдээлэл дээр үндэслэн бэлтгэж байна. Нэг талаас Засгийн газар хүлээн авсан орлогоо нөгөө талаас компаниуд төлсөн төлбөрөө цахимаар тайлагнадаг. Нэгтгэл тайланд материаллаг хэмжээгээр төлбөр төлсөн компаниудыг сонгосон. Мөн материаллаг хэмжээнээс бага хэмжээний төлбөр төлсөн жижиг компанийг түүврийн аргаар сонгосон байгаа. Засгийн газар 2017 онд 2,2 их наяд төгрөгийн орлого үүнээс нэгтгэлд хамрагдсан 230 компаниас 2,1 их наяд төгрөг хүлээн авсан. Үүнийг нэгтгэл буюу тохируулга хийсний дараа 2,2 их наяд төгрөг болж өссөн байна. Анх Засгийн газар 2,1 их наяд төгрөг хүлээн авсан гэж тайлагнасан харин компани 2,0 их наяд төгрөг төлсөн гэж тайлагнан анхны зөрүү 122,5 тэрбум байсан. Тохируулгын дараах тайлбарлагдаагүй зөрүү буурч 49 сая төгрөг болсон байна. Дээрх зөрүү 2 компаниас үүссэн, бид шалтгааныг тодруулах гэсэн боловч тэд хариу өгөөгүй.

Хамгийн их төлбөр төлсөн топ 10 компанид Эрдэнэт, Оюутолгой, Петрочайна Дачин тамсаг, Эрдэнэс таван толгой, Тавантолгой, Монголын алт МАК, Энержи Ресурс, Цайртминерал, Саусгоби Сэндс, Си Өү Эй Эл компаниуд байна. Эдгээр компаниуд нийт орлогын 85,5 хувийг бүрдүүлж байна.

Бид Засгийн газрын хүлээн авсан орлогын 95 хувь буюу ихэнх орлогыг нэгтгэл тайландаа хамруулж чадсан. Бүх Засгийн газрын байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд бидний хүссэн мэдээллийг өгсөн. Харин 42 компани цахим тайланд мэдээллээ оруулаагүй байсан нэмэлтээр мэдээлэл хүсч авсан. Тухайн компаниас ирүүлсэн мэдээлэл нь найдвартай эсэхэд баталгаажуулалт олгодог. Эхлэлийн үе шатанд олон талт ажлын хэсэгтэй зөвлөлдсөний дагуу цахим тайлангийн системээр дамжуулан тухайн байгууллагын захирлын гарын үсэг зурсан удирдлагын хариуцлагын захидал, аудитын захидал, аудитлагдсан санхүүгийн тайланг хүлээн авах шийдвэр гаргасан.

Ажлын хэсгийн шийдвэрийн дагуу Засгийн газрын байгууллагууд болон компаниуд дээрх шийдвэрийг хэрхэн биелүүлсэн талаар танилцуулъя. Бүх ТӨААН-үүд цахим тайлангийн системээр шаардсан мэдээллүүдийг ирүүлсэн. Харин улсын 7 байгууллага удирдлагын хариуцлагын захидлыг ирүүлж, 3 байгууллага ирүүлээгүй байна. Үндэсний аудитын газраас төрийн байгууллагуудад удирдлагын хариуцлагын захидал гаргаж өгөх талаар тэдний ажлын төлөвлөгөөнд багтаагүй учир дээрх мэдээллийг гаргаж өгөөгүй байна. Харин орон нутгийн түвшний зарим байгууллагуудыг аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна. Бүх ТӨААН-үүд цахим тайлагналыг ашиглан тайлангаа явуулаагүй харин хоёр ТӨААН тайлангаа ирүүлээгүй. Зарим ТӨААН-үүд аудиторын захидлаа мөн ирүүлээгүй байна. Олон талт ажлын хэсгийн зүгээс аудитлагдсан санхүүгийн тайланг хүлээн авах



шаардлага тавьсан харин гурван байгууллага өгөөгүй байна. Мөн зарим ТӨААН-ын аудитын тайлан хязгаарлалттай дүгнэлттэй гарсан байна. Энэ нь тухайн компанийн гаргасан тоон мэдээлэлтэй Үндэсний аудитын газар санал нийлээгүй байна гэсэн үг юм.

Үндэсний аудитын газрын цахим хуудсанд ТӨААН-үүдийн тайлангийн зарим хэсгүүдийг нийтэлсэн байна. Энэ нь бүрэн тайлан биш юм. Бүрэн бус тайлан гэдэг нь зөвхөн үндсэн гаргах ёстой 4 төрлийн тайлан байна, нэмэлт тодруулга тайлбар байхгүй байгааг бүрэн бус гэж үзнэ. Эндээс иргэд уул уурхайн талаарх ямар ч мэдээлэл авч чаддаггүй учраас иж бүрэн бус тайлан гэж үзсэн.

Нэгтгэлд хамрагдсан байгууллагаас төрийн өмчит байгууллагын хасаад 219 компани нэгтгэлд хамрагдсан үүнээс 42 нь цахим тайлангийн систем ашиглаагүй байна гэж тайланд дурдсан. Энэ компаниудаас хамгийн том нь Петрочайна Дачин тамсаг ХХК байсан. Эдгээрээс 24 компани бидний явуулсан удирдлагын хариуцлагын захидалд гарын үсэг зурж явуулаагүй мөн 18 компани аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна. ОУИТБС-ын орлогын 85 хувийг бүрдүүлсэн 10 компанийн 2 компани удирлагын хариуцлагын захидал ирүүлээгүй, 3 нь аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна. Сүүлийн 3 жилийн мэдээлэл ирүүлсэн байдлыг харьцуулахад төрийн өмчийн компаниуд удирдлагын хариуцлагын захидал ирүүлсэн байдал нэмэгдсэн боловч бусад үзүүлэлт нэмэгдээгүй байна. Компанийн хувьд тайлангаа өгөх болон удирдлагын хариуцлагын захидал ирүүлэх нь нэмэгдсэн боловч зарим мэдээллүүд буурах төлөвтэй байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-г ил тод болгоогүй, хуулийн төсөл 2012 онд гарсан боловч одоог хүртэл ил тод болсон гэрээ байхгүй байна. ОУИТБС-ын хүрээнд гэрээг ил тод байлгах стандартын шаардлагын дагуу гэрээний 3 мэдээллээс бусад нь ил тод болсон. ОУИТБС-ын цахим хуудасны зарим мэдээллүүд шинэчлэгдэхгүй байна. 2016 оны тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар танилцуулахыг стандартын дагуу шаарддаг. Энэ талаар ярья. 2016 онд өгсөн зөвлөмжийн 2 нь хэрэгжсэн, 4 нь хэрэгжээгүй байна. Иймээс цаашид нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай байна. Мэдээлэл авч шаардсан компаниудаас хуулийн энэ заалтыг зөрчиж байгаа эсвэл хязгаарлаж байгаа учраас бид энэ мэдээллийг өгөх боломжгүй гэж байсан учраас Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийг нэн даруй батлуулах шаардлагатай байна. Мөн тусгай зөвшөөрлийн ил тод байдлын асуудлыг дахин сайжруулах талаар зөвлөмж өгч байна. Энэ Үндэсний аудитын газартай хамааралтай. Бусад зөвлөмжүүдийг тайлангаас дэлгэрэнгүй харах боломжтой. Анхаарал тавьж сонссон Үндэсний зөвлөлийн гишүүдэд баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Дэлгэржаргал: За мэдээлэл хийсэн Харт Нойрс компанийн захиралд баярлалаа. Гишүүд асуулт, санал байвал өөрийгөө танилцуулаад асуултаа асууна уу.

Тохируулгын өмнө 2,145 их наяд төгрөг байсан бол тохируулгын дараа хүлээн авсан орлого нь 2,206 их наяд төгрөг болж 61 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна, энэ ямар шалтгаанаар нэмэгдсэн бол тайлбарлаж өгнө үү.

Н.Эрдэнэцог: Энэ нэмэгдсэн шалтгаан нь зарим санхүүгийн урсгалын хувьд нэмэгдээд зарим нь хасагдаад буруу ангилалд тайлагнасныг зөв ангилалд оруулж тохируулсан. Та бүхэн тайлангийн 2.4.3-аас залруулгыг харж болно. Тухайлбал, Татварын ерөнхий газар дээр 2,4 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ нь ТЕГ-ын тайланд Саус гоби сэндс компанийн татварын шалгалтаар илэрсэн нөхөн татвар болон НӨАТ-ын 2,4 тэрбум төгрөгийн татварыг тайлант хугацаанд төлсөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гэж тайлагнасан. Түүнийг нь бусад орлого гэдэг ангилал руу оруулж зөв болгож залруулсан байна. Мөн Гаалийн ерөнхий газар гэх мэт байгууллагад тохируулга хийхэд хүлээн авсан орлогын дүн нэмэгдсэн. Төрийн байгууллагуудад өгсөн хандив дэмжлэг нэмэгдсэн. Ер нь Засгийн газрын байгууллагуудын тайланд хандив тусламжийн мэдээлэл дутуу ордог зэрэг шалтгаанаар тохируулга хийгдсэн.

Б.Дэлгэржаргал: Газрын тосны бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн Засгийн газарт ногдох хувь хэмжээг мэдээлэх талаар тайланд зөвлөмж өгсөн байна. Өмнөх тайланд мөн өгсөн байсан. Харин энэ талаар мэдээлэх боломж байхгүй байгаа. Энэ талаар манай Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны түлшний бодлогын газрын ахлах мэргэжилтэн Пүрэв тодорхой хариулт өгөх хэрэгтэй байна.



н.Пүрэв: Зөвлөмжийн гуравт байгаа юм байна. Засгийн газарт ногдох хэмжээ гэдэг маань БХГ-ийн үндсэн нөхцөлд орж байгаа. Энэ тухай Газрын тосны тухай хуулийн 17,3-т байгаа асуудал байна. Ихэнх Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг нууцалдаг, хэрвээ гуравдагч этгээдэд үзүүлэх юм уу шилжүүлэх бол хоёр талын бичгээ өгсөн зөвшөөрөлтэйгээр үзүүлж болно гэдэг. Тэгэхээр манай гэрээлэгч тал маань үүнийг зөвшөөрдөггүй. Олон улсад нээлттэй тендерт өрсөлдөөд үндсэн нөхцөлд том тоонууд тавьсан байдаг, үүнийгээ нууцалдаг байна. Сүүлийн 2014 оны хууль батлагдсанаас хойш байгуулсан гэрээн дээр ил байлгах боломжтой байгаа үүнээс өмнө байгуулсан 10 гаруй гэрээн дээр Бүтээгдэхүүн хуваах гэрээний заалттай учраас нээлттэй байлгах боломжгүй байна. Үндсэн нөхцөлөөс бусад гэрээг нээлттэй тавихыг зөвшөөрсөн байгаа. БХГ-ний загвар гэрээ батлагдсан байгаа.

Б.Дэлгэржаргал: Олон улсад Бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод байлгах талаар ямар байдаг вэ? энэ талаар тайлбар өгнө үү.

Дэвид Куин: Гэрээг ямар хэмжээнд ил тод болгох вэ гэдэг нь тухайн улсын шийдэх ёстой асуудал гэж хэлмээр байна. Бусад улсуудын туршлагыг харахад БХГ-ээ бүхлээр нь ил тод болгосон улсууд байна. Ил тод болгосон гэрээний хуулбар надад байгаа. Арилжааны шинжтэй мэдээллүүдийг нууц байлгах ёстой гэдгийг ойлгож байна. АМНАТ-ын хувь нь нууц байгаа бол зөвхөн тэр хэсгийг нь хасаад ил болгох боломжтой. БХГ-г бүхэлд нь биш ч тодорхой хэмжээгээр ил тод болгох боломжтой.

н.Пүрэв. БХГ-г зүйл заалтаар нь ил болгож болно, бид компаниудаас зөвшөөрөл авсан байгаа гэхдээ үндсэн нөхцөл гэдэг нь роялти нь хэдэн хувь, Засгийн газарт оногдох нь хэдэн хувь байх юм урамшуулал хэд байх вэ гэх мэт үндсэн нөхцөлд байдаг тоонуудыг нууцалчихвал бусад бүх зүйл заалтууд нээлттэй байж болно.

Б.Дэлгэржаргал: За баярлалаа, роялти бол татвараас шууд гарах боломжтой. Бид одоо сүүлд хийсэн 3 гэрээг нээлттэй болж эхэлж байгаа, цаашдаа нэмэгдэх боломжтой.

Н.Эрдэнэцог: БХГ нь газрын тосны бүтээгдэхүүний орлоготой холбоотой юм. Ер нь өртөгт газрын тосны хувь болон Засгийн газрын хүлээн авсан орлогыг ил болгосон харин биет хэмжээгээр буюу барреллаар юм уу тонноор ил болгох нь боломжгүй гээд байгаа. Үүнийг ил тод болгочихвол цаана нь роялти болон өртөгт газрын тосны хувийг мэдэх боломжгүй. Мөнгөн дүнг нь тоон хэмжээнд шилжүүлэх асуудал нь ил тод болохгүй байгаа.

Б.Дэлгэржаргал: Тэр чинь шилжүүлээд гарчихгүй юу?

Н.Эрдэнэцог: Жишээ нь, Петрочайнаг мэдэх боломжгүй.

Д.Эрдэнэчимэг: Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг ил болгох шаардлага 2012 оноос биш 2015 онд Загвар гэрээг батлахад нууцлалын зэргийг хассан байгаа. Үүнээс хойш шинэ загвараар байгуулсан гэрээнүүдийг нууцлах шаардлагагүй гэж үздэг. 2017 онд Захиргааны ерөнхий хууль батлагдаад төрийн байгууллагатай байгуулсан гэрээг хэрвээ "Захиргааны гэрээ" гэж үзэх юм бол ил тод байх ёстой гэж үзэх хуулийн шаардлага байгаа. Энэ онуудыг залруулахгүй бол үндсэн тайлан болон танилцуулга дээр буруу байгаа учраас хүмүүст буруу ойлголт өгөх байх. Загвар гэрээ шинэчлэгдсэн батлагдахаас өмнө загвар-гэрээний 11 дүгээр зүйлд гэрээнд байгаа эдгээр мэдээллийг нууцлана гэж заасан байсан. Тэр мэдээллүүдийг хөөгөөд үзэхээр үндсэн гэрээнд байдаг мэдээллүүд байдаггүй хавсралтад байдаг мэдээллүүд байдаг. Тоон мэдээллүүдийг нууцлах заалт байдаггүй, харин тоон мэдээллүүдийг нууцалдаг. ОУИТБС-ын тайланд бүх төлбөр, хүлээн авсан орлого тайлагнагдаж байгаа юм чинь үүнийг ашиглан Засгийн газрын хүлээн авсан хувийг гаргах боломжтой юм шиг санагдаад байна, энэ хэр боломжтой вэ?



Ц.Уранцоож: За баярлалаа. Тайлан анх гарч байснаа бодвол нягтраад нимгэн болсон байна. Тайлан өөрөө их үнэ цэнэтэй гэвч хүмүүс ашиглаж чадахгүй байна. Тайланг таниулах, сурталчилах талаар Үндэсний зөвлөлийн шийдвэрт оруулмаар байна. Уул уурхайн орлогын 95 хувийг 10 компани бүрдүүлж байна гэдгийг Улсын их хурлын гишүүд мэдэж байх ёстой. Шийдвэрийн төслийг харахад хариуцлагатай холбоотой шийдвэр байхгүй байна. Мэдээллээ өгөөгүй, удирдлагын хариуцлагын захидлаа өгөөгүй хүмүүст яаж хариуцлага тооцох талаар шийдвэртээ оруулах шаардлагатай байна. Энэ заавал хийх ёстой ажил бөгөөд үүнийг нь хариуцлага болгох саналтай байна. Зөвлөмж дээр шаардлагатай мэдээллүүдийг өгөхгүй байгаа компаниудад ямар хариуцлага тооцдог талаар олон улсын туршлага байвал хэлж өгнө үү? Баярлалаа.

Дэвид Куин: Яг энэ хариуцлагын тухайд бид хариулах ёсгүй, харин Үндэсний зөвлөл шийдвэр гаргах ёстой. Харин бид энэ баталгаажуулалтын мэдээллийг авахын тулд нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай юм байна гэж үзэж байна

Б.Дэлгэржаргал: Бид олон улсад ямар байдаг талаар асуусан.

Дэвид Куин: Дээд шатандаа хариуцлагын талаар санал оруулах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Б.Дэлгэржаргал: Баярлалаа. Асуулттай холбоотой гэрээний загвар батлах тухай тогтоол байгаа. Тогтоолоо Үндэсний зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлаар зөвлөмж гаргаж, олон нийтэд мэдээлэх гэсэн заалт байгаа. Цаашдаа урт хугацаандаа хариуцлагын талаар ажиллах хэрэгтэй байх.

Г.Уранцоож: АМГТГ-ын дарга л гэхэд удирдлагын хариуцлагын захидлаа өгөөгүй байна. Төрийн байгууллагын хариуцлагатай албан тушаалтан, үүргээ биелүүлэхгүй байна тэгэхээр нэг юм хэрэгтэй байгаад байна.

Д.Цэрэнжав: ОУИТБС-ын тайланд бичил уурхайн талаарх мэдээлэл оруулдаг болсонд баяртай байна. Тайлангийн хавсралт 28,29-т бичил уурхайн мэдээлэл, орон нутаг дахь төрийн бус байгууллагуудын мэдээлэл байгаа гэсэн боловч энэ хавсралтад байхгүй байна. Энэ цахим тайлан дээр байна уу эсвэл дараа нөхөж орох уу?

Н.Эрдэнэцог: Хавсралт нь хэвлэхэд их зузаан болох гээд байсан учраас зарим хэсгийг хасаж хэвлэсэн.

Д.Галбаатар: ОУИТБС-ыг ойлгохдоо ил тодоор тайлагнах, стандартыг боловсронгуй болгох ёстой гэж ойлгосон. Бид тайланг бэлтгэхдээ Нягтлан болох бүртгэлийн стандартаар гаргаж байгаа. Бид тайландаа өнөөдөр ирээдүй цагийн орлогыг суулгаж байна, ирээдүй цагийн ашгийг нь урьдчилаад авчиж байна. Байгалийн баялагийн нөөцийн хорогдлыг өмч болгоод явж байна гэх мэт. Олборлох үйлдвэрлэлийн тайлагналийн стандартыг боловсронгуй болгох талаар олон улсад юу хийгдэж байна, яригдаж байгаа санал санаачилгууд байна уу? Зөвхөн санхүүгийн стандартаа барьж байна уу?

Ш.Цолмон: ОУИТБС-ын стандарт 2016 онд батлагдсан, 33 үзүүлэлттэй үүнээс манай улсын үнэлгээг 28 үзүүлэлтээр нь хийж, үзүүлэлтийг хангасан орноор тодорсон байгаа. Цаашдаа, тайлагналын том нүсэр байдлыг аль болох багасгах, цаг хэмнэсэн, бүгдийг нь биш



голыг нь тайлагнадаг болох талаар яригдаж байгаа. 2019 оны 7 сард болох ОУИТБС-ын Олон улсын бага хурлаар шийдвэр гарах байх. Төрийн ихэнх байгууллагууд цахим хуудсандаа бага зэргийг засвар үйлчилгээ хийгээд ил тод болгох боломжтой орлогын бус мэдээллүүдийг ил болгох, тухайн мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага өөрөө хариуцах байдлаар хийхээр төлөвлөж байгаа. Мөн аудиторроор ийм нүсэр ажил хийлгэхгүй байхыг зорино.

Д.Галбаатар: Өнөөдөр АМНАТ-ийг борлуулалтын үнэлгээн дээр хийж байна. Борлуулалтын үнэлгээ гэдэг бол аудитын байгууллагаас гэрээний үнэлгээн дээр хийдэг аргагүй юм. Өнөөдөр Австралийн нүүрсийг Монголын нүүрстэй жишиж байгаад АМНАТ-ын жишиг үнэ тогтоож байна. Ийм хачин замбараагүй зүйлүүдийг боловсронгуй болгоно гэж яригдсан гэж би ойлгосон. Байгалийн нөөцийн хорогдлын зардлыг Эрдэнэт үйлдвэр 51 болгоод буулгачихсан. Энэ нь бусад монголын үйлдвэрүүдэд яагаад байхгүй байна вэ? гэх мэт юмнуудыг асуугаад байна.

Дэвид Куин: ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангийн шаардлага илүү энгийн байдаг. Жишээлбэл, АМНАТ-д хэдэн төгрөг авсан бэ гэдгийг тайлагнадаг харин хэрхэн тооцсон тухай мэдээлэл шаарддаггүй. Санхүүгийн тайлан нь аккрузель сууриар тайлагнадаг бол ОИУТБС-ын тайлан мөнгөн сууриар тайлагнадаг гэхдээ хол зөрүүтэй мэдээлэл гарахгүй.

Б.Болдбаатар: Жижиг сажиг алт олборлодог хүмүүсийг барих боломжгүй болсон. Сэлэнгэ аймгийн гол дагасан алттай сумуудад олон тооны хүмүүс алт олборлож байна. Үүний хэд нь хувиараа алт олборлогч, хэд нь хулгайч гэдгийг тогтоох боломжгүй байна. Айл болгон хашаанд экскаватортай, зундаа 500 гаруй экскаватор ажилладаг гэсэн тоо байдаг. Иймээс хөшүүрэг хэрэглэхгүй бол тайлангаа үнэн зөв гаргуулж чадахгүй. Ерөнхий сайдын дэргэдээс танай бодлогын яам руу ирсэн байна. Тайлангаа гаргахгүй байгаа байгууллага дээр авах арга хэмжээний хөшүүрэг боловсруулах хэрэгтэй. Зөв сайн хийж байгааг нь Үндэсний зөвлөлийн хурлаар сайшаагаад, буруу болохгүй байгаад нь ямар нэгэн арга хэмжээ авахаар шийдвэрлэх нь зүйтэй байхаа. Улсын их хурлын танхимд ихээхэн хэмжээний нүүрс алдагдсан гэдэг асуудал гарсан. Тэр нь аль талдаа хаана тайлагнасан байдаг вэ?

Н.Эрдэнэцог: Тайлангийн хавсралт 18 дээр борлуулсан нүүрсний мэдээлэл байгаа. Бид зөвхөн гаргаж өгсөн мэдээллээр нэгтгэл тайланд тусгана. Харин гаргаж өгч байгаа мэдээлэл үнэн зөв эсэхэд түрүүний шаардаад байгаа баталгаажуулах мэдээллийг авч байгаа.

Б.Болдбаатар: Энэ талаар шийдвэрийн төсөлдөө оруулах саналтай байна. Бид ОУИТБС-ыг хэрэгжүүлээд 12 жил болоод байна. 2010 оноос үүнийг өргөжүүлэе гэж ярьж байсан. Үүнээс болоод 300,400 тонн нүүрс алга болчихоод байна.

Б.Дэлгэржаргал: Энэ асуудал эртнээс эхэлсэн. Анх авсан геодезийн зурагзүйн байршилийн зураг өөрчлөгдсөн байдаг. Жижиг Таван толгой олборлолт хийгээд дунд нь хана үүссэн, түүнийг авахаар нурахаар байсан мөн дээгүүр нь зам явж байсан. Хоёр таван толгой ярилцсаар байгаад 260.000 тонн нүүрс гэдэг дээр тогтсон. Сүүлдээ улс төржөөд өөр өөр тоо гаргасан. Энэ асуудлын талаар хэрхэн яаж шийдэгдсэн талаар манай нэгтгэл тайлан дээр байхгүй. Энэ зүгээр байж байгаад гэнэт алга болсон зүйл биш, аль аль нь мэдэж байсан асуудал.



Г.Батцэнгэл: Тайлангийн зөрүүг бараг 1000-аад хувь буулгаж, тохируулсан байна. Улаанбаатар аудит болон Харт Нойрсын хамт олонд талархсанаа илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна. 2016 онд хөндлөнгийн хараат бус хянан нэгтгэгчээр ажилласан. Нэг жилийн дараа ирэхэд ямар өөрчлөлт гарсан байна вэ? мэргэжлийн хүний нүдээр харахад ямар ахиц дэвшил гарсан байна уу? гэж асуумаар байна.

Дэвид Куин: Монгол улс баталгаажуулалт хийгдээд хангалттай үнэлгээ авсан байсан, үүнд баяр хүргэмээр байна. Энэ жилийн зөрүү өмнөх жилүүдээс багассан байна. Үүнээс харахад сайжирсан байна гэж ойлгож байна. Монголын ОУИТБС-ын хүрээнд тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил тод болгодог болсон байна. Мөн бусад хэд хэдэн мэдээллийг ил тод болгосон байна. Энэ бүгдийгээ цаашид улам сайжруулах нь зүйтэй. Мөн бусад улсуудыг бодвол нээлттэй хэлэлцэх асуудал байдаг.

Н.Баярсайхан: Юуны өмнө тайланг боловсруулсан Улаанбаатар аудитад баярласнаа илэрхийлье. Тайланд хэд хэдэн газарт тайлан гаргаагүй компаниудад хариуцлага тооцох анхаарах зөвлөмж өгсөн байна. Үүнийг УУХҮ-ийн яам яаж арга хэмжээ авах боломжтой талаар үндэслэлээ гаргаж байж, шийдвэрээ гаргах нь зүйтэй байх. Мөн энэ тайланг Улсын их хурал, түүний хороодод танилцуулахаар шийдвэрийн төсөл оруулмаар байна. Тэгэхээр энэ асуудалд Уул уурхайн яамны хэм хэмжээ хүрэх үү? Ямар шийдэл байгаа талаар асуумаар байна. Тайлангийн өмнөх зөрүү болон тохируулгын дараах зөрүүн дээр БОАЖЯ-тай холбоотой томоохон зарүүний асуудлууд гарсан байна. БОАЖЯ Олборлох салбарын орлогоос ямар төрлийн орлогыг хүлээн авдаг талаар тодруулж өгнө үү. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 2016 оныхоос 2 дахин багассан байна. Энэ ямар учиртай талаар тайлбарлаж өгөхийг хүсье. Мөн хавсралт 11 дээр төрийн байгууллагуудад олгосон хандив тусламжийн жагсаалт байна. Энд “Говийн Оюу” хөгжлийг дэмжих сан 11 тэрбум төгрөг хүлээн авсан гэж байна. Үүнтэй адил Дорноговийн хөгжлийн сан гэж байх ёстой, тайлагнаагүй байна. Энэ сан багагүй хэмжээний мөнгө хүлээн авч, зарцуулсан байгаа. Энэ нь тайланд байхгүй, зөрүү нь тусгагдаагүй байна. Энэ ямар учиртай вэ? Засгийн газрын олборлох салбараас хүлээн авсан орлогыг хэн ямар компани бүрдүүлээд байгааг гаргасан байна. 2.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна, үүнийг ашигт малтмалын төрлөөр нь гаргаж болох уу? Тухайлбал, нүүрс алт гэх мэтээр. Бусад жижиг техникийн шинжтэй засварууд оруулмаар байна.

Б.Дэлгэржаргал: Уул уурхайн яам бүх аймгуудтай гэрээ хийгээд, тайлангийн талаарх асуудлыг дүгнэнэ. Үүн дээр ОУИТБС-ын тайлангаа хэрхэн гаргасан, хэрвээ гаргаагүй бол гэрээгээ сунгах уу гэдэг дээр ярина. Ерөнхий сайд ажлын ачааллын улмаас манай яам руу шилжүүлсэн. Бид Засгийн газрын хэрэг эрхлэх газар дээрээ байвал яасан юм бэ гэдэг саналыг ярилцаж байгаа. Энэ талаар 4 дүгээр асуудал дээр ярилцана.

Н.Эрдэнэцог: БОАЖЯ-тай холбоотой мэдээлэл дээр тохируулга хийгдсэн. Байгаль орчны барьцаа хөрөнгийн дүн 7,5 тэрбум гэж тайлбарласан. Гэтэл 969 сая төгрөг хүлээн авсан байсан. Тайлангаа гаргахдаа өссөн дүнгээр анх байгуулагдсан цагаас хойш дансанд төвлөрсөн мөнгөө тайлагнасан байсан. Оюутолгой компани “Говийн оюу” хөгжлийн санд 1 тэрбум төгрөгийн хандив өгсөн гэж тайлагнасан. Бид цаад газраас нь асуугаад тайлагнаад зөрүүг тааруулсан. Харин Дорноговь аймгийн хөгжил сан аль ч талаасаа тайлагнаагүй учраас гарч ирээгүй. Орлогын ашигт малтмалын салбараар гаргах боломжтой. Оюутолгой компани гэхэд зэс, алт олборлоно. Үүний орлогыг хуваарилахад яаж хуваах вэ гэдэг



асуудалтай. Татвар нь нэг төлөгдөж байгаа учраас салгах шаардлага гарна. Ер нь төслөөр тайлагнах гэдгээр гарч ирэх боломжтой гэхдээ бас төвөгтэй асуудал байгаа.

Н.Баярсайхан: Ашигт малтмалын төрлөөр эсвэл геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэр гээд салбараар гаргах боломжтой байна уу? Энэ нь маш чухал хэрэгтэй мэдээлэл болоод байна. Ямар нэгэн байдлаар тооцоолсон аргачлалаа тайлбарлаад, ойролцоогоор ингэж гаргалаа гээд тайландаа оруулвал сайн байна. Бид 10 жил тайлан гаргачихаад ашигт малтмалын төрлөөр гаргаж чадахгүй байна гэдэг чамлалттай байна.

Н.Эрдэнэцог: Хэдэн төрлийн ашигт малтмалын төрлөөр үйл ажилладаг компани нүүрсэн дээрээ ашиг олдог алтан дээрээ алдагдалтай байлаа гэхэд тус компани Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 100 сая төгрөг төлчихсөн байхад яаж хуваарилах вэ? гэдэг асуудалтай.

Н.Баярсайхан: Тэгвэл зөвлөмж дээрээ тодорхой санал гаргамаар байна. маягтаа ингэж засмаар байна, эрхзүйн орчноо ийм болгомоор байна гэдгээ зөвлөмж байдлаар тусгамаар байна.

Н.Эрдэнэцог: Төслөөр тайлагнах дээр тусгасан байгаа, түүнийгээ баяжуулаад явж байна.

Д.Эрдэнэчимэг: ТАН эвслээс гурван тусгай зөвшөөрлийн мэдээлэл өгсөн, тэр ороогүй байх шиг байна. Энэ талаар тайлбар өгнө үү. Мөн шийдвэрийн төслийн 6.а-д Үндэсний зөвлөлд тайлагнах гэж нэмж оруулмаар байна. Учир нь бид жил бүр ийм шийдвэр гаргадаг. Зөвлөмжийн дагуу хичнээн компанид хариуцлага тооцсон, түүнээс үндэслээд тайлан гаргах үйл явц сайжирч байна уу гэдэг нь мэдэгддэггүй. Ялангуяа газрын тосны компаниудыг оруулмаар байна. Олборлосон, борлуулсан бүтээгдхүүнээ тайлагнах үүрэгтэй ч дутуу тайлан өгөөд байгаа газрын тосны компаниудыг нэр зааж оруулж өгөхийг хүсье.

Н.Баярсайхан: Улсын их хурлын төсвийн байнгын хороонд тайланг танилцуулах мөн сурталчилах ажлыг "... орон нутгийн захиргаа, дэд зөвлөл,ТАН эвсэлд болон Уул уурхайн ассоциацид " даалгах гэж шийдвэрийн төсөлд нэмж оруулах саналтай байна.

Б.Саран: Тайланг харахад Байгаль орчны яаманд хамааралтай хэсэгт үг үсгийн алдаа их байна. Орлого төвлөрүүлсэн гэсэн, байгаль орчны барьцаа хөрөнгө нь орлого биш. Их багын асуудлыг энд ярьж болохгүй. Тухайн компанийн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 50 хувийг төвлөрүүлдэг учраас их багаар уралдуулах нь буруу юм. Тайлангийн 135 дугаар хуудсанд байгаа хүснэгтийг залруулмаар байна. Барьцаа хөрөнгө нь 2007 оноос хойш төвлөрүүлж байгаа энэ жил нилээн хүчин чармайлт гаргаж байж нэрээр нь гаргасан байна. Эрдэнэт гэхэд 200 сая төгрөгийн барьцаа хөрөнгө төвлөрүүлсэн байдаг. Тухайн эвдсэн газартай харьцуулахад энэ зардал их багыг тооцоход хэцүү. 2017 онд 1 тэрбум гаруй төгрөг төвлөрүүлсэн. Ер нь барьцаа хөрөнгийг буцааж авах ёстой хөрөнгө юм.

Н.Эрдэнэцог: Ер нь англи стандартаас орчуулахаар төлбөр орлого гэдэг нэр томъёо гарч байгаа. Байгаль орчны барьцаа хөрөнгө нь хүлээгээд авсан учраас хүлээн авсан орлого дотроо орж байгаа.



Б.Дэлгэржаргал: За гишүүдийн саналыг сонслоо. Гишүүдээс гаргасан саналыг тусгаж оруулах гэсэн байдлаар эхний асуудлын шийдвэрийн төсөлд санал хураая. Гишүүд дэмжсэнээр шийдвэрийн төслийг батлав

## **2. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Монголын ОУИТБС-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай**

Ш.Цолмон: За баярлалаа, 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2019 оны төлөвлөгөөний төслийг нэгтгэн товчхон танилцуулна.

2018 онд нийт 75 үйл ажиллагааг ажил хийхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар 54 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 74 байгаа. Ажлын хэсэг 3 удаа, дэд хэсэг 2 удаа хуралдсан.

Хийгдсэн томоохон ажлуудыг дурдвал, ОУИТБС-ын баталгаажуулалтыг амжилттай хийлгэж, сайн үнэлгээ авсан, 2017 оны ОУИТБС-ын тайлан гаргах аудиторын түншлэлийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж Улаанбаатар аудит корпораци болон Харт Нойрс түншлэл шалгаран 2018 оны 6 сард гэрээ байгуулж, 8 дугаар сард эхлэлийн тайлан, 11 дүгээр сард тайлангийн төслөө танилцуулсан. Ажлын хэсгийн хурлын зөвлөмжийн дагуу тайлангийн эцсийн хувилбарыг өнөөдөр танилцуулж байна. 2017 оны тайланг ОУИТБС-ын стандартын дагуу бэлтгэн боловсруулж, 230 компанийн тайланг Засгийн газрын тайлантай тулган баталгаажуулж, өнөөдөр дүнг танилцуулж байна. Компани, Засгийн газрын байгууллагуудын 2017 оны тайлагнах ажлыг зохион байгуулж, 1489 компани, төрийн 7 агентлаг, 9 дүүрэг, 21 аймаг ОУИТБС-ын тайлан гаргасан байна. Нийт 2091 компаниас орлого хүлээж авсан байна. Ил тод хариуцлагатай уул уурхай-2018 сургалтыг зохион байгуулж, 150 гаруй компанийн төлөөлөл оролцсон. Эрдэнэс монгол ХК-тай хамтран Төрийн өмчийн компаниудад зориулан санхүүгийн ажилтнуудын мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэх сургалт хийсэн. БОАЖЯ-тай хамтран “Байгаль орчны мэдээлэл олон талт оролцогчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан. Усны ил тод байдлын талаарх асуудлыг шинээр хэлэлцэн, ус ашигласны тайлангийн маягыг баталсан. 113 компани ус ашигласан тухай мэдээллээ ил тод болгосон. Ил тод сан ТББ-тай хамтран сэтгүүлчдийн сургалт, Олон улсын санхүүгийн байгууллага Инновацийн төвтэй хамтран 40 гаруй оюутан сурагчдад тоон мэдээлэл ашиглах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Орон нутгийн мэдээллийн ажлын хүрээнд Миний монголын газар шороо ТББ, Хөвсгөл далайн эзэд, Их баян шарга ТББ-тай хамтран Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Төв аймгийн Заамар, Булган аймгийн Дашинчилэн суманд уулзалтыг 6 дугаар сард, Байгал эхийн аврал сан ТББ-тай хамтран 7 дугаар сард Увс аймгийн Хяргас суманд ОУИТБС-ын өдөрлөгийг тус тус зохион байгуулсан. Дөрвөн жишиг сумын мэдээллийн ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалтыг 5 дугаар сард цахимаар зохион байгуулсан. 12 дугаар сард Увс аймгийн төв Улаангом суманд ОУИТБС-ын Баруун бүсийн чуулганыг зохион байгуулсан. Чуулган АТГ, БОАЖЯ, АМГТГ, ТЕГ, ТАН эвсэл болон Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын мэдээллийн ажилтан оролцсон. Суртчилгааны ажлын хүрээнд Мэгүүн медиа ХХК-тай гэрээ байгуулж, 6 дугаар сард олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай ажлыг зохион байгуулсан. Жишиг сум тус бүрийн мэдээллээр сонин бэлтгэн хэвлэж, орон нутагт хүргүүлсэн. ЕСБХБ-ны санхүүжилтээр “Ашиг хүртэгч эцсийн эзний ил тод байдал, Монгол улсын бодлого” сэдвээр зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. Монголын ОУИТБС-ын үйл ажиллагаа ахиц дэвшлийн тайланг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна. Оролцогч талууд маань 2018 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээллээ ажлын албанд өгөх хэрэгтэй байна. Мэдээллийг энэ ахиц дэвшлийн тайланд оруулах юм.

2019 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд таван чиглэл, үндэслэлийг баримталсан. Үүнд, ОУИТБС-ын стандартад заасан санхүүгийн бус мэдээллийг төрийн байгууллагын системээр тогтмол ил тод болгох ажлыг хэвшүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд 9 ажил, Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг дахин боловсруулж, УИХ-аар батлуулах зорилгын хүрээнд 5 ажил, Ашиг хүртэгч эцсийн эздийн ил



тод байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоог сайжруулах, туршилтаар мэдээлэл цуглуулах зорилгын хүрээнд 7 ажил, Монгол улсын ОУИТБС-ын 2018 оны тайлангийн нэгтгэлийн явцыг сайжруулах, тайланг хэлэлцэн батлах зорилгын хүрээнд 5 ажил, Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний үр нөлөө, ач холбогдол, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, ашиг хүртэгч эцсийн эздийг зарлах зэрэг асуудлыг оролцогч талуудад таниулан сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгын хүрээнд 13 ажлыг тус тус хийхээр төлөвлөөд байна. Ингээд Үндэсний зөвлөлийн гишүүд Та бүхэн ажлын төлөвлөгөөтэй танилцаад саналаа өгч, баталж өгөхийг хүсье./Танилцуулгыг хавсаргав/

Б.Дэлгэржаргал: Танилцуулгын дагуу асуух асуулт байвал асууж болно.

Н.Баярсайхан: 2019 онд ажлын алба ямар төсөвтэй байхаар байна. Улсын төсвөөс байх уу? Өөр эх үүсвэр байна уу?

Ш.Цолмон: Төсөв маань ойлгомжгүй байгаа. Улсын төсвийн хөрөнгөөр хийгддэг нэгтгэл тайлангийн ажлын 254,4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Ажлын албаны хувьд санхүүжилт тодорхойгүй байгаа. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны санаачилгаар Азийн хөгжлийн банктэй ярилцаж, тооцоолол хийж ярилцаж байгаа. Ирэх оны 3 дугаар сараас эхлүүлэх чиглэлтэй байгаа. Бид байгаа мөнгөний хэмжээнд биш хийх ажлынхаа хүрэн ажлаа төлөвлөсөн. Болох байх гэж найдаж байна.

Б.Дэлгэржаргал: Бид 289 дүгээр тогтоол гарахыг мэдээгүй байсан. Хэрвээ бид мэдсэн бол Уул уурхайн яамны төсөвт суулгах боломжтой байсан. Энэ нөхцөл байдал гэнэт үүссэн, 2019 оны төсөвт байхгүй. Иймээс бололцоо нөхцлөө хангаж ажиллахаар ярьж байна. Засгийн газар дээр төсөв байхгүй, шийдвэрлэх хүрээнд бололцоогоороо ажиллаж байна.

Д.Эрдэнэчимэг: Бид тогтоолын төсөл боловсруулаад, өнөөдрийн хуралдаанаас хэлэлцүүлээд Засгийн газарт өргөн барих гэж байна. Үүнийгээ ажил болгож төлөвлөгөөн дээрээ оруулах хэрэгтэй байна. Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах, батлуулах чиглэлийн ажлуудаа тавиад тодорхой төрийн байгууллагуудад хандсан, чадавхи бэхжүүлэх ажил үүрэг, хуваарийг тодорхой болгох нь чухал байх. Ашиг хүртэгч эцсийн өмчлөлтэй холбоотой асуудал байгаа. Бид өөрсдөө хуулийн нэр томъёогоо цэгцлээд явахгүй бол ийш тийш санал өргөн барихаар өөр өөр байхаар санал маань уначих асуудал байдаг. Иймээс эцсийн өмчлөгч гэдэг нэр томъёогоо цааш нь хэрэглээд явах санал байна. Үнэт цаасны төлбөр тооцооны төв гэж байдаг. Тэнд байгууллага хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн бүртгэл байдаг. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл бүрэн гарахгүй гэж үздэг яагаад гэвэл дээрх мэдээлэл өдөр бүр өөрчлөгдөж байдаг. Гэтэл хуулийн этгээдийн бүртгэлийн газрын мэдээлэл хуучирсан мэдээлэл болох юм. Иймд тэр хоёр байгууллагын хувьд мэдээлэл солилцдог болгохгүй бол үнэн зөв мэдээлэл гарахгүй байна. Хувьцаа эзэмшигчийн мэдээллийг ил тод болгож байгаа нь ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгож байгаа асуудал биш. Тиймээс Ашиг хүртэгч эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох ажил хиймэээр байна, хуулийн нөлөөллөө зогсоомооргүй байна.

Н.Баярсайхан: Бид 2018 онд тайлагналаас шийдэл рүү гэсэн зорилттой байсан. Үнэндээ шийдэл рүүгээ орж чадаагүй байгаа. Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд хариуцлага тооцохгүй байгаа учраас 2019 оноо тодорхой уриатай болгоё гэсэн санал байна. Зөвлөмжийг хэрэгжүүлэх, талуудын хариуцлагыг сайжруулах асуудлын талаар 2019 оны төлөвлөгөөнд тодорхой бие даасан зорилт болгон оруулах саналтай байна. Гэрээг ил тод болгох ажил дутуу явж байгаа. Нэг байгууллага сайт хийсэн, энэ талаар төр компани ямар ч санаачилга гаргахгүй байна. Тэгэхээр гэрээг ил болгох асуудлыг нэг зорилт болгож оруулах нь зүйтэй



гэсэн саналтай байна. Тодорхой ажлуудаа зорилт болгоод явах нь зөв байх. Уул уурхайн орлогоос улсын төсөвт 2,2 их наяд төгрөг төвлөрүүлчихээд энэ жижигхэн ажлын албыг ажиллуулж чадахгүй, төсөв байхгүй гээд сууж байгаа нь ичмээр байна. Тийм учраас Засгийн газар төсөвт тодотгол хийх боломж байна уу, Ерөнхий сайдын, Шадар сайдын нөөц сангаас гарах боломж байна уу? энэ талаар санал хүргүүлвэл ямар вэ? Улсын их хурал, Төсвийн байнгын хороонд ОУИТБС-ын тайлангаа танилцуулна гэдэг нь энэ механизмыг ажиллуулахад мөнгө хэрэгтэй байна гэдэг санааг давхар ойлгуулах ёстой юм. Тэгэхээр дээрх саналуудыг хурлын шийдвэр болон ажлын төлөвлөгөөндөө тусгах саналтай байна.

Б.Дэлгэржаргал: Бид нар тогтоолын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах санал хэлэлцэнэ гэхдээ Засгийн газар дэмжих үү гэдэг чинь хэцүү иймээс бид оруулах асуудлаа оруулаад явах нь зүйтэй. Гишүүд шийдвэрийн төслийг батлав

### **3. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Олборлох үйлдвэрлэлийн ашиг хүртэгч эздийн ил тод байдлын “Замын зураг”хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухай.**

Б.Дэлгэрмаа: Сайн байцгаана уу. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зураг маань / бүлэг 32 үйл ажиллагаанаас бүрдэнэ. 2020 оны 1 сарын 1 гэхэд уул уурхайн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тендерт оролцогч ханган нийлүүлэгчтэй компанийн ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох зорилготой замын зураг байгаа.

Хэрэгжилтийн хувьд 2017,2018 онд 1,3,5 дугаар зорилт руу түлхүү анхаарч ажилласан. Ашиг хүртэгч эцсийн эздийг ил болгох асуудлыг үндэсний тэргүүлэх шинэчлэлийн бодлоготой уялдуулах гэсэн нэгдүгээр зорилтын хүрээнд нээлттэй засаглалын Үндэсний зөвлөлтэй уулзалт зохион байгуулсан. 2018 оны 5 дугаар сард Төрийн ордонд УИХ, Засгийн газар, бусад оролцогч талуудын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулсан. Хоёрдугаар зорилтын хүрээнд 3 ажил хийхээр төлөвлөсөн байснаас хоёр нь хэрэгжиж, нэг ажил нь хойшлогдсон байна. Үүнд, 2018 оны 2 дугаар сард Уул уурхайн яамтай хамтран АХЭ-ийн мэдээллийг бүртгэдэг төрийн байгууллага болох Үнэт цаасны хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк, Аудит газар, статистикийн хороо зэрэг бүхий л холбоотой байгууллагуудын удирдах түвшний ажилтнуудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Манай ажлын албаны хуульч холбогдох хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, УИХ-ын гишүүн Б.Мөнх-Оргилд танилцуулсан. Энэ талаарх УБЕГ-аас санал авах шатандаа явагдаж байна. 2019 ондоо цахим системийг сайжруулах замаар хэрэгжээд явна. Гуравдугаарт, Оролцогч талууд зөвшилцсөний үндсэн дээр “Ашиг хүртэгч эзэд”-ийн талаарх тогтсон нэр томъёо тодорхойлолт, хамрах хүрээ, материаллаг босго мэдээллийн нарийвчлалын түвшин, тайлагналын хугацааны үечлэлтэй болох ажлын хүрээнд 8 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд бүрэн хэрэгжсэн гэж үзэж байгаа. Бүх талуудын оролцуулан 260 гаруй хүнээс санал авч дүнг 2017 оны Үндэсний зөвлөлийн хурлаар танилцуулж байсан. Нэгдсэн нэг нэр томъёотой болоод түүнийгээ Хууль зүй дотоод хэргийн яаманд албажуулаад явсан. Замын зургийн тавдугаар ажлын хүрээнд ЕСБХБ-ны тусламжтайгаар ажлууд хийгдсэн. Тухайлбал, Нээлттэй нийгэм форумын санаачилгаар компани, иргэний нийгмийн цуврал хэлэлцүүлгийг 2018 оны 9,12 дугаар сард зохион байгуулсан. Мөн ЕСБХБ-ны санхүүжилтээр 12 сард уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2019 онд улс төрд нөлөө бүхий этгээдийн ашиг хүртэгч эздийн мэдээллийн бүрэн ил болгохоор зорьж байгаа. 2018 оны төлөвлөгөөнөөс 32 үйл ажиллагаанаас 17 нь буюу 53 хувийн биелэлттэй байна. Энэ жил ашиг хүртэгч эздийн мэдээллийг хувь хүний регистрийн дугаартай нь ил болгосон. Энэ мэтчилэн мэдээлэл сайжирч байгаа гэж болно. компаниудтай холбогдох сүлжээг өргөжүүлж байна. Зөвхөн Уул уурхайн ассоциациар хязгаарлахгүй Худалдаа аж үйлдвэрийн танхим болон бусад танхимтай хамтран ажиллаж, мэдээлэл өгч, нийтэд сурталчилж байна. Бид Ашиг хүртэгч эздийн ил болгох гарын авлагыг бэлтгэн тараасан. 2019 онд төрийн байгууллагын мэдээлэл цуглуулах системийг боловсронгуй болгох, ЕСБХБ-ны санхүүжилтээр ажлууд хийгдэнэ. Жинхэнэ эзэн мөн үү гэдэг дээр төрийн байгууллага эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сэтгүүлчидтэй хамран ажиллахгүй бол дангаараа



хийж чадахгүй нь тодорхой байгаа. Хууль батлуулах чиглэлээр тусгай ажлын хэсэг гаргая, үүнд төрийн байгууллагууд дэмжлэгтэй ажиллах байх. Эрдэс баялагийн салбар дахь ил тод байдлын тухай хуулийг батлуулахад эрхзүйн орчныг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Мэдээллээ сайн дураар ил тод болгож байгаа компаниудыг урамшуулж, туршлагыг нь хуваалцаж ажиллахаар төлөвлөж байна. Ялангуяа жинхэнэ эзнийг тогтоох эрэн сурвалжлахад дэмжлэг үзүүлж ажиллахаар зорьж байна. Баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Дэлгэржаргал: За баярлалаа, асуулт саналтай гишүүд гараа өргөнө үү.

Б.Мөнхбат: Санал болгож байгаа нэр томъёололыг дэмжиж байна. Ажлын албаны цаашдын үйл ажиллагаа явуулах боломж, төсөв мөнгийг тодорхой болгох хэрэгтэй. Өмнө нь бид хуралдсаны дагуу Ажлын албыг ЗГХЭГ-ийн харъяанд байх ёстой гэж үзсэн. Үүнийг тогтоолын төсөлд хэвээр байлгахыг хүсье. Ер нь салбарын яамны харъяанд байж болохгүй, ач холбогдлыг шууд бууруулна. Өмнө нь манай геологийн салбар тусдаа харъяа яамтай байсан. Сүүлийн 10 гаруй жил өөрийн яамгүй болж, салбарын яаманд харъяалагдсанаар уналтад орсон гэж үздэг. Үүнтэй нэгэн адилаар ОУИТБС-ын Ажлын албаны маань ирээдүй үүнтэй адилхан битгий болоосой гэж бодож байна.

Д.Эрдэнэчимэг: Хэрэгжилт үр нөлөөг бид яаж дүгнэх ёстой вэ? Уулзалт хийсэн бол хэрэгжсэн гэж үзэх юмуу? Ер нь зөвхөн замын зураг ч биш жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үр ашиг, үр нөлөөг сайн тодорхой бичиж байвал сайн байна. Ер нь төлөвлөгөө тайлан гэдэг бол зөвхөн ажлын албаных биш Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хамтран хийсэн нэгдсэн тайлан байдаг. 2018 оны 5 сард зөвлөлдөх уулзалт хийсэн, энэ ажлыг хэрэгжсэн гэж байна. Тэр уулзалтад үнэндээ Улсын их хурлын нэг ч гишүүн байгаагүй. Зарчмын хувьд тайлангаа ажлын алба бэлдээд ажлын хэсгээр оруулж, нилээд санал авч боловсруулаад Үндэсний зөвлөлд танилцуулах нь зүйтэй гэсэн санал байна. Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас санхүүжүүлсэн уулзалтыг зохион байгуулахад манай ажлын алба болон ТАН эвсэл нилээд ажилласан. Эдгээрийг нэмээд оруулах санал байна. Мөн төлөвлөгөөний 5-ын 3-т эрэн сурвалжлах нэвтрүүлэг бэлдэж байна гэсэн. Энэ нь тусдаа ажил байна уу? эсвэл ТАН эвсэл дээр хийсэн ажлыг хэлж байгаа бол ТАН эвсэл болон ННФ-ийг оролцсон гэж оруулах нь зүйтэй байна.

Б.Дэлгэрмаа: ЕСБХБ-ны санхүүжилтээр хийгдсэн ажилд ажлын албыг оролцуулаагүй. Юу болоод байгааг бид мэдээгүй, Эрдэнэчимэгээс гуйж авсан. Тэр ажлуудыг тайланг багцаагаар хийсэн. Телевизийн нэвтрүүлгийг ЕСБХБ-ны хийж байгаа ажил гэж ойлгож байгаа.

Д.Эрдэнэчимэг: Нэвтрүүлэг бэлтгэх ажлын эрэн сурвалжлах зардлыг манай форумас гаргасан.

Ш.Цолмон: Тайланг ажлын хэсэгт танилцуулах цаг байгаагүй, амжаагүй. 5 дугаар сарын уулзалтад Аюурсайхан гишүүн оролцсон. Тэрнийг зохион байгуулах ажил нь хүнд байсан, бүх байнгын хороогоор орж танилцуулсан. Бүгдээрээ за гэхихээд цагаа тулахад ирээгүй. Ер нь цаашдаа иймэрхүү ажилд хэд хэдэн хүн явмаар юм байна. Хуулиудын нэмэлт өөрчлөлтийг Мөнх-Оргил гишүүнд танилцуулахад за гэсэн. Гэтэл одоо болтол дараад л байж байна.

Б.Дэлгэрмаа: Бид үр нөлөөг судлаад мэдлэг, мэдээлэл хэр зэрэг нэмэгдсэн бэ гэдгийг гаргахад тусдаа судалгааны байгууллагаар хийхгүй бол шууд хэмжиж болохгүй байгаа.

Д.Эрдэнэчимэг: Тоогоор хэмжиж болохгүй байж болно. Энэ санаачилгыг хэрэгжүүлснээр салбарын ямар өөрчлөлт гарсан, бодлогын ямар томоохон өөрчлөлт гарсан талаар тусгамаар байна. Жишээ нь, БХГ-г нууцлалыг зэрэглэлээс хасдаг чинь бидний хийсэн уулзалт, хэлэлцүүлгээс болсон гэх мэт бодлогын хүрээнд гарч байгаа томоохон өөрчлөлтүүдээ томъёолж, олонд таниулж явахгүй бол зөвхөн тайлан гаргадаг гэдгээс өөр юм



байхгүй, хуулийн төсөл маань унасан байгаа. Тайландаа биш гэхэд тусдаа танилцуулга бэлтгэж байх нь зүйтэй байна.

Н.Баярсайхан: ЕСБХБ маш том төсөл хэрэгжүүлсэн, их хэмжээний төсөвтэй байсан. Тэгэхээр ЕСБХБ-ны төслийн тайланг сонсох ажлыг 2019 онд хиймээр байна. Ажлын албыг оролцуулдаггүй, тайлан мэдээгээ өгдөггүй юм байна. Бид төслийн бичиг баримтыг үзээгүй. Бид нар гаднын компаниудын мөнгө угаадаг хэрэгсэл болоод байж болохгүй. Тиймээс 2019 оны төлөвлөгөөндөө тус төслийн тайланг сонсох, үнэлэх гэж оруулах саналтай байна. Энэ ОУИТБС-ын үйл ажиллагааны тайлангаа хэнд зориулж бичихээ сайн тодорхойлмоор байна. Бид жил бүрийн тайланг өмнө нь Олон улсын дарга нарын газарт зориулж бичиж байсан бол одоо олон нийт иргэдэд зориулж бичмээр байна. Энэ тайлангаа улам сайжруулаад текст хэлбэрт оруулаад, зурагтай, өнгөтэй материал болгоод хэвлэх ажлыг хийх санал байна. Мөнх-Оргил гишүүн тэр эрдэс баялгийн илтөд байдлын тухай хуулийн төслийг өргөн барихгүй. Иймээс өөр хүнд эсвэл Уул уурхайн сайдад танилцуулаад, лобби бүлэг байгуулаад ажиллах хэрэгтэй. Талуудаас төлөөлөл сонгоод, үүний хойноос явмаар байна. Сэтгүүлчдийн хооронд халз мэтгэлцээн хийх зэргээр ажиллах санал байна.

Б.Дэлгэржаргал: Танилцуулгатай холбогдон гарсан саналыг тусгах гэсэн хувилбараар саналаа хураая. Шийдвэрийн төслийг батлав

#### **4. ХЭЛЭЛЦСЭН НЬ: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.**

Б.Дэлгэржаргал: 2018 оны 289 дүгээр тогтоолтой холбоотойгоор ажлын хэсэг томилж, тогтоолын төсөл боловсруулсан. Олборлох салбар нь ДНБ-ийн 20 хувь, экспортын бараг 90 хувийг эзэлж байгаа том салбар байгаа. Иймээс Уул уурхайн яаманд байхаас илүү ЗГХЭГ юмуу Ерөнхий сайдын дэргэд байх нь зүйтэй гэж Ажлын хэсгээс санал нэгдэн энэхүү тогтоолын төслийг оруулахаар бэлтгэсэн. Тогтоолын төслийг хэвлэн та бүхэнд тараасан байгаа, уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд байвал гараа өргөн үү.

Н.Баярсайхан: Төслийг юу ч гэсэн ингээд танилцуулаад үзье гэсэн үү, эсвэл шадар сайд, Ерөнхий сайдын ахлах зөвлөхтэй зөвлөлдөөд энэ төслийн гаргасан уу? Тогтоолын төслийг хүлээж авахгүй байвал яах вэ? Гурван талын төлөөлөл Ерөнхий сайдтай уулзмаар байна. Тэрээр шударга ёсыг тогтооно, авилгыг бууруулна гэж ярьж байгаа. Энэ цаг мөчид ОУИТБС-ын статус бууруулан яамны харъяалалд оруулдаг нь хэр оновчтой юм бэ? энэ талаар гишүүдийн төлөөлөл Ерөнхий сайдтай уулзах саналтай байна.

Б.Дэлгэржаргал: Бид өмнө нь Ерөнхий сайдын зөвлөх болон шадар сайдтай уулзаагүй зөвхөн ажлын хэсгээрээ нэгдсэн шийдэлд хүрээд саналаа боловсруулаад Үндэсний зөвлөлд танилцуулж байна. Хэрвээ Үндэсний зөвлөлөөр дэмжвэл дараагийн ажлуудыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн. Эхлээд үндсэн ойлголтуудаа өгөхгүй шууд оруулвал унах магадлалтай.

Н.Баярсайхан: Иргэний нийгмийн байр суурь нь Ерөнхий сайд дээрээ байсан нь дээр гэж үзэж байгаа. Тэгэхээр манай гишүүд хаана байсан нь зөв гэж үзэж байна вэ? байр сууриа нэг болгох нь зүйтэй байх.

Д.Цэрэнжав: Бид ажлын хэсгээрээ ЗГХЭГ гэж шийдсэн.



Д.Сүхбаатар: Манай Үндэсний зөвлөл маань чадамжгүй, толгойгүй, утгаа олохоо болиод байна. Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоол гэж байна.

Б.Дэлгэржаргал: Бид тогтоолын төслөө өнөөдөр дэмжвэл, дараагийн шатны ажлуудаа ярих юм. Бүх юмаа анхнаас нь танилцуулна.

Д.Цэрэнжав: Бид нилээн ярилцаад хамгийн боломжит хувилбарыг олсон гэж бодож байна. Бид Ерөнхий сайд, ерөнхийлөгч хэнд ч хариуцуулсан бай явсаар байгаад доод талын аппарат дээр очдог. Тиймээс ийм дэмий юманд санаа зовж байхаар сайдуудын дарга гэдэг утгаар нь ЗГХЭГ-ийн дарга гэдэг дээр санал нэгдэж, батлаад цааш нь лоббидох ажлаа хийсэн нь дээр байх.

Д.Галбаатар: Байгалийн баялагтай улс орныг дэмжих хамгаалах чиглэлээр их том бодлого явуулж байсан байна. Үүнээс 2002 оны Тони Блэйрийн ОУИТБС гэсэн санаачилга гарч ирсэн. Үүний бид зөв ашиглаж чадвал сайн байна. ЗГХЭГ гэж байгаа ч хамгийн их ажлын нугалдаг газар бол ажлын алба юм. Өдий хүртэл энэ бүх ажлыг ажлын алба хийсээр байгаад дэлхийн жишигт хүргэсэн, стандартыг хэрэгжүүлж байгаа хоёрдогч орон гэдэг үнэлгээгээ ч авсан. Англи улс байгаа жаахан нүүрсээ боловсруулах гэж хөрсөө бараг гурав эргүүлсэн. Тэгээд энэ салбарын стандарт нь өөр байх ёстой гэдгийг тогтоосон. Өнөөдөр санхүү, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт гэдэг нэг хэрэг. Таван сая төгрөг нь зөв үү, буруу гэдэг асуудлыг агуулгаар гаргаж ирэх стандарт нь ОУИТБС-ын стандарт юм. Бусад аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийг бүтээгдхүүн нэмэгдээд байвал өртөг буурдаг, харин жижигхэн уул уурхай уулын геологийн нөхцлөөс болоод үйлдвэрлэл нэмэгдсэн мөртлөө өртөг нэмэгдээд байдаг. Ийм боломжийг гаргах гэж байгаа, үүнийг сайжруулах гэж байгаа санаачилга гэж ойлгодог. Өнөөдөр бид тайлан хийж байна, дэвшил олсон байна. Үүгээрээ дамжуулаад байгалийн баялагтай улс орон давуу чанараа ашиглаад цаашдаа Монгол улс яаж байх вэ гэдгийг бий болгох том хариуцлагыг бидэнд өгсөн байна. Өнөөдөр уул уурхайд шууд өртөгт суудаг хөрс хуулалт гэж зардал байна. Тэр бидний ирээдүй цагийн зардал, өнөөдөр бидний бий болгосон овоолгууд бидний ирээдүй цагийн ашиг байдаг. Энэ зүйлүүдийг зөв болгох зам буюу боломж бол ОУИТБС гэдэг утгаар нь би дэмждэг юм. Тийм учраас гарсан саналууд болон ажлын төлөвлөгөөг бүрэн дэмжиж байна. Монгол улс энэ санаачилгыг авч явах хөрөнгө дутаад байна уу? үндсэндээ дөрвөн хүн л цалинжуулах асуудал байна ш дээ. Энийг энд ярьмааргүй байна.

Б.Болдбаатар: Тогтоолын төслийг дэмжиж байна. Ерөнхий сайд бэлэг тэмдгийн байдлаар оролцоод эсвэл хүнээр үг дайгаад яваад байна. Эндээс бидний гаргасан шийдвэр, зорилтуудыг шийдвэрлэх тал дээр ЗГХЭГ илүү хүрэх байхаа.

Д.Цэрэнжав: Он гараад ажил хэвийн явагдана, тайлангаа хэвлүүлэх тараах гэх мэт. Яамны төлөөллийн хувьд ямар төлөвлөгөөтэй байна.

Б.Дэлгэржаргал: Тогтоол гарсан гараагүй ажил явдагаараа явна. Гагцхүү тогтоолын саналаа дэмжчихвэл дараагийн ажлууд болон лоббидох хүмүүсээ ажлын хэсгээсээ томилох юм.

Ц.Уранцоож: Тогтоолын төслийг дэмжиж байна.

Д.Эрдэнчимэг: 289 дүгээр тогтоолыг хүчингүй болгохоор 222 дугаар тогтоол чинь хүчинтэй хэвээрээ үлдэнэ. Иймээс “Үндэсний зөвлөлийн бүрэлдхүүнийг” гэснийг хасах ёстой



юм байна. 2019 оны төсөв батлагдсан учраас 2020 оноос гэж оруулсан байгаа. Азийн хөгжлийн банкнаас 3 сараас төсөл хэрэгжиж магадгүй гэж ярьж байгаа ч тэр болтол Нээлттэй нийгэм форум дата системээ хариуцаж ажилладаг хүнийг цалинжуулахаар болсон байгаа. Бусдыг нь арай чадсангүй гэхдээ өөр боломж гарч магадгүй.

Ш.Цолмон: Манай төслийн мөнгөнөөс ашиглагдаагүй үлдэгдэл байгаа үүнийг ашиглах талаар Уул уурхайн яам болон Дэлхийн банк ярьж байгаа.

Б.Дэлгэржаргал: Боломжтой бол гаднын санхүүжилтийн талаар тогтоолд оруулж болохоор бол оруулъя. Хуульчдаас асууя, хэрвээ болж байвал дэмжлэг болох байх. За ингээд тогтоолын төсөл өргөн барихыг дэмжих гэдгээр санал хураая.

Гишүүд 100% дэмжсэнээр шийдвэрийн төслийг батлав. Тогтоолын төсөл өргөн барих лобби бүлэгт оруулах гишүүдийн нэрсийг өгнө үү.

Н.Баярсайхан: Талуудаас хэдэн хүн оруулах вэ гэдгээ тохироод дотроо ярилцаад нэрсээ өгье.

Б.Дэлгэржаргал: Ерөнхийдөө талууд нэрсээ ажлын албанд өгчих. За цаг зав гарган, хуралдаанд оролцсонд баярлалаа.

Хуралд 18,20 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,  
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн  
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн  
ахлагч

Г.Нандинжаргал

Тэмдэглэлийг хянасан:

УУХҮЯ-ны УУБГ-ын дарга

Б.Дэлгэржаргал

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,  
Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн  
ажилтан

А.Отгонтунгалаг



## МОНГОЛ УЛСЫН ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 17 ДУГААР ХУРАЛДААНЫ ШИЙДВЭРҮҮД

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 17 дугаар хуралдаан 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 15.20 цагт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2 дугаар давхар хурлын танхимд эхэлж, 18,20 цаг төгсөв.

Хуралдааныг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Г.Нандинжаргал нээж, Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал удирдан явуулав.

### Шийдвэрүүд:

#### **Хэлэлцсэн асуудал 1. Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны буюу арван хоёрдугаар тайланг хэлэлцэж, батлах тухай:**

Монгол Улсын “Улаанбаатар аудит корпорац”, Их Британийн “Харт Нойрс” компаниудын консорциумыг төлөөлж, “Харт Нойрс” компанийн захирал Д.Куинн, Улаанбаатар аудит Корпорац ХХК-ийн ахлах аудитор Н.Эрдэнэцог, нар хамтран танилцуулав.

1. Монгол Улсын “Улаанбаатар аудит корпорац”, Их Британийн “Харт Нойрс” компаниудын консорциумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны буюу 12 дугаар нэгтгэл тайланг дэмжиж, хуралдаан дээр гишүүдээс гаргасан саналыг тусган батлахаар тогтов.
2. Монгол Улсын 2017 оны тайланг оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, Ажлын албанаас хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.
3. Монгол Улсын 2017 оны нэгтгэл тайлан, 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай тайлан, 2019 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2018 оны 12 дугаар сарын 31- ний дотор хүргүүлэхийг Ажлын албанд даалгав.
4. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэвлэлийн мэдээллийн хэсэгт даалгав.
5. Гэрээт ажлын үлдэгдэл мөнгийг Монгол Улсын “Улаанбаатар аудит корпорац”, Их Британийн “Харт Нойрс” компаниудын консорциумд төлж барагдуулахыг Ажлын албанд зөвшөөрөв.
6. Энэхүү тайлангаар өгсөн зөвлөмжүүдийн хүрээнд дараах шийдвэрүүдийг гаргав.Үүнд:
  - a. ОУИТБС-ын 2017 оны тайлангаа гаргаагүй компаниудын нэрсийг өдөр тутмын сонинд хэвлэн нийтлэх, Улсын мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж хариуцлага тооцуулахыг Ажлын албанд даалгав;
  - b. Улсын Мэргэжлийн хяналтын газраас тайлан гаргаагүй компаниудтай хариуцлага тооцсон тайлан мэдээллийг Үндэсний зөвлөлд 2019 оны 1-р улиралд багтаан танилцуулахыг даалгав.
  - c. Олгогдсон тусгай зөвшөөрлүүдийн өргөдлийн огноог Кадастрын санд оруулж ил тод болгохыг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгав.
  - d. Газрын тосны бүтээгдэхүүний гэрээний ил тод байдлыг бүрэн хангах боломжийг нягтлан үзэж, нийтэд ил тод болгохыг УУХҮЯ-нд даалгав.



- e. Газрын тосны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, тухайн жилд олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний биет хэмжээг нийтэд ил тод болгоогүй гэрээт компаниудын нэрсийг Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж, хариуцлага тооцсон тайлан мэдээллийг Үндэсний зөвлөлд 2019 оны 1-р улиралд багтаан танилцуулахыг Ажлын албанд даалгав.
- f. Аймгийн засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэж, Үндэсний зөвлөлд 2019 оны 1-р улиралд багтаан мэдээлэл өгөхийг УУХҮЯ-д санал болгов.
- g. Ашигт малтмалын төрлөөр нь төсөвт оруулж буй, хувь нэмрийг ангилж 2017 оны нэгтгэл тайланд оруулж өгөхийг хянан нэгтгэгч консорциумд санал болгов.
- h. УИХ-ын ЭЗ болон Төсвийн байнгын хороодод 2017 оны нэгтгэл тайланг 2019 оны 1-р улиралд багтаан танилцуулахыг ОТАХ/Ажлын албанд даалгав.
- i. Тодруулгад хариу өгөөгүй төрийн болон ААН, байгууллагуудын нэрийг өдөр тутмын сонинд нийтлэхийг Ажлын албанд даалгав.

**Хэлэлцсэн асуудал 2. Монголын ОУИТБС-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай:**

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав.

1. Монголын ОУИТБС-ын 2018 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2019 оны ажлын төлөвлөгөөтэй танилцаж, гишүүдийн саналыг тусган батлав.
2. Монголын ОУИТБС-ын 2018 үйл ажиллагаа, ахиц дэвшлийн тухай үйл ажиллагааны тайланг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
3. Ахиц дэвшлийн тайланд оруулах оролцогч тал болох Засгийн газар, компани, иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн ажлын товч танилцуулгыг 12 дугаар сарын 28-наас өмнө Ажлын албанд ирүүлэхийг УУХҮЯ, Монголын УУҮА, ТАН, МБОИЗ-д санал болгов.
4. Ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажлыг дэмжих ЕСБХБ-ний төслийн явц, үр дүнг ОТАХ-ийн 1-р улирлын хуралд танилцуулахыг Ажлын албанд даалгав.

**Хэлэлцсэн асуудал 3. Олборлох үйлдвэрлэлийн ашиг хүртэгч эздийн ил тод байдлын “Замын Зураг” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухай:**

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа танилцуулав.

1. Ашиг хүртэгч эцсийн эздийг ил тод болгох замын зураг-2020 он” төлөвлөгөөний биелэлтийн явц, шинэчилсэн төлөвлөгөөг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
2. Ашиг хүртэгч эздийн тодорхойлолт, нэр томъёог хуульд заасны дагуу жигдрүүлж, мөрдүүлэхийг Ажлын албанд даалгав.



**Хэлэлцсэн асуудал 4. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай:**

УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал танилцуулав.

1. Засгийн газрын тогтоолын нэмэлт өөрчлөлтийн төслийг гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
2. Холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанд оруулж, батлуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны уул уурхайн бодлогын газар-т даалгав.
3. Тогтоолын үзэл баримтлалыг ЗГХЭГ- д танилцуулах Ажлын дэд хэсгийг байгуулах, дэд хэсэгт орох төлөөллийн нэрсээ оролцогч талууд 12 дугаар сарын 31-нээс өмнө ирүүлэхээр тогтов.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,  
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн  
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн  
ахлагч



Г.Нандинжаргал

Хянасан

УУХҮЯ-ы УУБГ-ын дарга



Б.Дэлгэржаргал

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,  
Ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг